

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2014 ОНЫ 14 ДҮГЭЭР ХУРАЛДААН

Хуралдаан 2014 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн 14 цаг 06 минутад эхэлж, 15 цаг 13 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 07 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Дээд Шүүхийн Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай	Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Лүндэндоржийн 2014 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 01/639 тоот албан бичгээр Улсын дээд шүүхийн Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай захиалга Төрийн албаны зөвлөлд ирсний дагуу уг ажлын байранд томилогдох сонгон шалгаруулалтыг 2014 оны 4 дүгээр сарын 24-ний өдрөөс эхлэн Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, 2014 оны 5 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулахаар тогтов.
2	Үндсэн хуулийн Цэцийн Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай	Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн дарга Ж.Амарсанаагийн 2014 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 1/126 тоот албан бичгээр Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай захиалга Төрийн албаны зөвлөлд ирсний дагуу уг ажлын байранд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулахаар тогтов.
3	Нийслэл болон Дархан-Уул, Дундговь, Баян-Өлгий аймагт зохион байгуулсан	Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны

<p>төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн албаны мэргэшлийн шалгалтын дүнгийн тухай</p>	<p>зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2014 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр Нийслэлд зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :</p> <p>1. Нийслэлд 2014 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 133 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэх.</p> <p>2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 2 дугаар хавсралтад нэр бүхий 28 иргэнийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлэх.</p> <p>3. Энэхүү тогтоолын 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 28 нэр дэвшүүлсэн иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1-д заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөл /Ё.Гэрэлчулуун/-д үүрэг болгох.</p> <p>4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын</p>
---	---

		<p>Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2014 оны 04 дүгээр сарын 10-17-ны өдрүүдэд Баян-Өлгий аймаг, Дундговь аймаг, Дархан-Уул аймагт зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :</p> <p>1. Баян-Өлгий аймаг, Дундговь аймаг, Дархан-Уул аймагт 2014 оны 04 дүгээр сарын 10-17-ны өдрүүдэд зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1, 2, 3, 4, 5, 6 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий нийт 133 иргэнээс 43 иргэн /Баян-Өлгий аймагт 10, Дундговь аймагт 18, Дархан-Уул аймагт 15/-ийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, 90 иргэн /Баян-Өлгий аймагт 66, Дундговь аймагт 14, Дархан-Уул аймагт 10/-ийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д тус тус бүртгэх.</p> <p>2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 7, 8, 9, 10, 11, 12 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 21 иргэн /Баян-Өлгий аймагт 3, Дундговь аймагт 12, Дархан-Уул аймагт 6/-ийг, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн</p>
--	--	---

		<p>өндөр оноо авсан нэр бүхий 22 иргэн/Баян-Өлгий аймагт 12, Дундговь аймагт 7, Дархан-Уул аймагт 3/-ийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар тус тус нэр дэвшүүлэх.</p> <p>3. Энэхүү тогтоолын 7-12 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 43 нэр дэвшүүлсэн иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1-д заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Төрийн албаны зөвлөлийн Баян-Өлгий аймаг дахь салбар зөвлөл /Т.Манкей/-д, Дундговь аймаг дахь салбар зөвлөл /О.Чулуунбат/-д, Дархан-Уул аймаг дахь салбар зөвлөл /Ч.Чүлтэмбат/-д тус тус үүрэг болгох</p> <p>4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
4	Зарим албан хаагчдад төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгуулах тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 20 дугаар зүйл, “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журмыг батлах тухай” Улсын Их Хурлын 1995 оны 73 дугаар тогтоолоор баталсан журмын 2, 6 дахь заалт, “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журамд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын 2000 оны 20 дугаар тогтоолын 1-д заасны дагуу төрийн захиргааны албан тушаалын тэргүүн болон эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв олгуулахаар ирүүлсэн саналыг хэлэлцээд, дөрвөн албан хаагчид тэргүүн түшмэлийн, 12 албан хаагчдад эрхэлсэн түшмэлийн</p>

		зэрэг дэв олгуулах саналыг Засгийн газарт уламжлахаар шийдвэрлэв.
5	Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын Хүүхэд, гэр бүл, хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн Д.Оюунсүрэнгээс гаргасан гомдлын талаарх Маргаан хянан шалгах комиссын дүгнэлт	<p>Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын Хүүхэд, гэр бүл хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн Д.Оюунсүрэнгээс тус аймаг дахь Салбар зөвлөлийн 2014 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 03 дугаар хуралдааны шийдвэрийг эс зөвшөөрч Төрийн албаны зөвлөлд гаргасан өргөдөл үндэслэлтэй эсэхийг шалгасан Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1, 39.5, Улсын Их Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”-ын “Нэг” дэх хэсгийн 3.6-д заасныг удирдлага болгон:</p> <p>1.Төрийн албаны зөвлөлийн Баянхонгор аймаг дахь Салбар зөвлөлийн “Нэр дэвшүүлэх тухай” 2014 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 03 дугаар тогтоолын Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтсийн даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалттай холбогдох хэсгийг хүчингүйд тооцох.</p> <p>2.Баянхонгор аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтсийн даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтыг дахин явуулж дүнг Төрийн албаны зөвлөлд ирүүлэхийг тус аймаг дахь Салбар зөвлөлийн дарга О.Тойвгоод даалгах.</p> <p>3.Төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны сонгон шалгаруулалтад оролцогч нарыг тухайн ажлын байранд тавигдсан ерөнхий болон тусгай шаардлагад нийцүүлэн бүртгэж байхыг Баянхонгор аймаг дахь Салбар зөвлөлд</p>

		анхааруулах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
--	--	--

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ